



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар A/302

Арвайхээр

Г Захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Орон тооны жишиг норматив батлах тухай” А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Орон тоо батлах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/68 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулиудын түр ажиллах орон тоо”-ны 6 дахь хэсгийн Хархорин сумын 1 дүгээр сургуулийн үйлчлэгч 0 гэснийг 1 гэж, манаач жижүүр 0 гэснийг 1 гэж, 7 дахь хэсгийн Хархорин сумын 2 дугаар сургуулийн үйийн цайны тогооч 0 гэснийг 1 гэж, гуравдугаар хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын 2021 оны багш, ажиллагсдын орон тоо”-ны 25 дахь хэсгийн Бат-Өлзий сумын 2 дугаар цэцэрлэгийн эмч 0.5 гэснийг 1 гэж тус тус өөрчлөн нэмсүгэй.

2.Батлагдсан орон тоог 2021 оны төсвийн жилд мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагчид үүрэг болгосугай.

3.Батлагдсан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идерсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А. ИШДОРЖ

011100644